



# “ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2025 оны 3 сарын 18



# ҮЭ-ИЙН ХОРООНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- ▶ Тэргүүлэгчдийн зөвлөл-17 тэргүүлэгч гишүүн
- ▶ Хяналтын зөвлөл-3 гишүүн
- ▶ Нэгдсэн гишүүдийн тоо-2000
- ▶ Даргын ажлын алба-3 ажилтан үүнд:
  - ҮЭ-ийн Хорооны дарга
  - ҮЭ-ийн Хорооны менежер
  - ҮЭ-ийн Хорооны санхүүгийн ажилтан
- ▶ Сайн дурын сонгуульт ажилтан 20, орон тооны ажилтан 2, орон тооны бус ажилтан 1 нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй тус ҮЭ-ийн Хорооны өдөр тутмын үйл ажиллагаа явагдаж байна.



- ▶ ҮЭ-ийн Хорооны дотоод дүрмийн 13 дугаар зүйлын 13.1,13.3 заалтуудын дагуу ҮЭ-ийн Хорооны удирдлага, шийдвэр гаргах эрхийг ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗӨВЛӨЛ хэрэгжүүлнэ.
- ▶ ҮЭ-ийн Хорооны дотоод дүрмийн 18 дугаар зүйлын 18.1,18.5 заалтуудын дагуу Тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэр тогтоол, хэрэгжилт, санхүүгийн орлого, зарлага мөн даргын ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүргийг ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ хэрэгжүүлнэ.

- ▶ ҮЭ-ийн Хорооны дотоод дүрмийн 15 дугаар зүйлын 15.2,15.5 заалтуудын дагуу өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн үйл ажиллагааг хангах, удирдан зохион байгуулах, гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэн, Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл, бүх гишүүдэд ҮЭ-ийн Хорооны зорилт, төлөвлөгөө, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг ДАРГА болон АЖЛЫН АЛБА хүлээнэ.
- ▶ ҮЭ-ийн Хорооны санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу баримт бүрдүүлэлт, санхүүгийн тайлан, хөрөнгө зарцуулалтыг МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК 2023 оны 2 сарын 1-ээс Санхүү, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээг гэрээ байгуулан ажиллаж байна.



# ҮЭ-ИЙН ХОРООНЫ АЛБАН БИЧИГ, ХУРАЛ, ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ (ТООН ҮЗҮҮЛЭЛТ)

- ▶ Нийт явсан албан бичиг\_54
- ▶ Ирсэн албан бичиг\_41
- ▶ Гишүүдээс ирсэн санал хүсэлт\_667
  - цалин хөлс, хэвийн бус нөхцөл, зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэлтэй холбоотой хүсэлт шийдвэрлэгдсэн\_629
  - удирдлага, дотоод журам\_11
  - ажлаас халагдсан тухай\_3
  - сонгуульт ажилтны тухай\_24
- ▶ Тэргүүлэгчдийн гаргасан тогтоол\_57
- ▶ Тэргүүлэгчид ээлжит хуралдаан\_2
- ▶ Тэргүүлэгчид ээлжит бус хуралдаан\_1
- ▶ Онлайн хуваарьт хуралдаан\_22
- ▶ Онлайн хуваарьт бус хуралдаан\_11
- ▶ [OTTU](#) домайн нэр хаяг шилжүүлсэн.
- ▶ [www.othu.mn](http://www.othu.mn) цахим хуудсанд тавигдсан мэдээлэл\_11
- ▶ [www.othu.mn](http://www.othu.mn) цахим хуудсанд шинэ гишүүнээр элсэх анкет харагдах байрлал болон бусад өөрчлөлт хийсэн.
- ▶ Цахим хуудаст 2025-2027 оны Хамтын гэрээг байршуулав.
- ▶ Цахим хуудаст 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг бүрэн эхээр нь байршуулав.
- ▶ Цахим хуудсын хандалт\_92295
- ▶ Мессеж санал асуулга бүх гишүүдэд\_3 удаа
  - Хамтын гэрээний санал\_2
  - Та цалингаа бодож чаддаг уу\_1 (98% чаддаггүй )
- ▶ ОТ ҮЭХОРОО ТАТВАР ТӨЛӨГЧДИД ФБ группэд тавигдсан мэдээ пост \_195



# НИЙТ ГИШҮҮДЭД 2024 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖИЛ

- ❖ “ОЮУТОЛГОЙ” ХХК БОЛОН “ОЮУТОЛГОЙ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙН ТОХИРОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ ХИЙГДСЭН. 2024 ОНЫ 4 САРЫН 18
- ❖ ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГЫН СОНГУУЛЬ АМЖИЛТАЙ ХИЙГДЭЖ, КОМПАНИЙ ҮНДСЭН АЖИЛТНААС ДАРГА СОНГОГДОВ. 2024 ОНЫ 6 САРЫН 03
- ❖ “ОЮУТОЛГОЙ” ХХК БОЛОН “ОЮУТОЛГОЙ” ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО, ОЮУТОЛГОЙН ОРОН НУТГИЙН АЖИЛЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО ХАМТРАН 2025-2027 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН. 2024 ОНЫ 11 САРЫН 23
- ❖ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

..\2025.03.18\2025.02.18 Тайлан мэдээлэл.xlsx



# ХАМТАРСАН ГЭРЭЭ БОЛОН ХАМТЫН ГЭРЭЭГЭЭР ЦАЛИН ХӨЛС НЭМЭГДҮҮЛСЭН БАЙДАЛ

- ▶ **Хамтарсан ажлын хэсгийн тохиролцоог хэрэгжүүлэх гэрээгээр:**
  - Нийт ажилтнуудын үндсэн цалинг 2024 оны 4 дүгээр сарын 1-ээс 3%+4% нэмэгдүүлсэн.
  - Инженерүүдийн албан тушаалын үнэлгээ зэрэглэл нягтлахад 1419 ажилтанг хамруулсан ба 617 ажилтны зэрэглэл өөрчлөгдөж, цалинг 3-15% нэмэгдүүлсэн.
- ▶ **Хамтын гэрээгээр:**
  - Нийт ажилтнуудын үндсэн цалинг 2025 оны 3 сарын 1-ээс \$200-оор нэмэгдүүлсэн.
  - Ажилтны нэг цагийн дундаж цалин хөлс тодорхойлоход нийт цагийн хязгаарыг нэг сард 168 цаг байхаар тусгасан.
  - Илүү цагийн нэмэгдэл хөлсийг 1,6 дахин нэмэгдүүлж олгож эхэлсэн
  - Шөнийн ээлжийн нэмэгдэл хөлсийг 1,3 дахин нэмэгдүүлсэн.





# ХАМТАРСАН ГЭРЭЭ БОЛОН ХАМТЫН ГЭРЭЭГЭЭР ГИШҮҮД АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙЖРУУЛАЛТ

## ▶ Хамтарсан ажлын хэсгийн тохиролцоог хэрэгжүүлэх гэрээгээр:

- Нийт ажилтнуудын эрүүл мэнд сайн сайхны байдалд зориулан ажилтан бүрд 1,000,000.00 (нэг сая) төгрөгийн нэг удаагийн тусламж өгсөн.
- Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд гэр бүлийн 2 гишүүнийг хамруулсан. Нийт 4331 ажилтны гэр бүлийн 7185 хүн хамрагдсан байна.
- УБ оффисийн ажилтнуудын хоол унааны хөнгөлөлт 500,000.00 мян төгрөгийг 800,000.00 мян төгрөг болгосон.

## ▶ Хамтын гэрээгээр шинээр нэмэгдсэн заалтууд

- Ажилтнуудын хүүхдүүдэд зориулан дотоодын их дээд сургуульд суралцах тэтгэлгийг жил бүр 30 оюутанд олгож эхэлсэн.
- Ажилтны байнга оршин суудаг гэр орон байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдсэний улмаас сүйдсэн бол 10,000,000.00 сая төгрөгийн тусламж үзүүлэх.
- УБ оффисийн ажилтнуудын хоол унааны хөнгөлөлт 800,000.00 мян төгрөгийг 1,000,000.00 төгрөг болгосон.
- Амаржсан эхэд 18-н долоо хоногийн үндсэн цалинтай тэнцэх тэтгэмжийг олгоно.





# ҮЭ-ИЙН ХОРООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГА





# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

- ▶ Гишүүд ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангах зорилгоор тус ҮЭ-ийн Хороо байгуулагдсан цагаас хойш Монголын Эрчим хүч Геологи Уул уурхайн ҮЭ-ийн Холбооны гишүүн байгууллагаар ажиллаж мэргэжил эрх зүйн зөвөлгөө авах, сургалт, зөвлөгөөнд оролцон хамтран ажиллаж байна.
- ▶ Тус Холбоогоор дамжуулан Олон Улсын Аж үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн Холбоо ( IndustriALL Global Union)-той хамтын ажиллагааг эхлүүлэн ҮЭ-ийн Хорооны үйл ажиллагааг танилцуулан, гэрээ хэлэлцээрийн тухай туршлага солилцох уулзалтууд хийгдсэн.
- ▶ Шинээр байгуулагдсан Оюу Толгойн Орон нутгийн ажилчдын ҮЭ-ийн Хороотой хамтран ажиллаж Хамтын гэрээ-г амжилттай үзэглэлээ.



# МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБОО

- ▶ Салбар, аймаг, нийслэлийн гишүүнчлэл 197,015 байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар
- ▶ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3-н талт хэлэлцээрийг шинэ түвшинд хийж байгуулсан. ( МҮЭХ, МУ-ЫН ЗГ, МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБОО)
- ▶ Тус хэлэлцээрээр хэрэгжүүлсэн гол ажлууд
  - Нийт төрийн албан хаагчдын цалин хөлсийг 10%
  - Нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20%
  - Суманд ажиллах төрийн захиргаа, үйлчилгээний бүх албан хаагчдад үндсэн цалинг 40%
  - Аймгийн төв нийслэлийн алслагдсан 3-н дүүргийн төрийн албан хаагчдийн цалин 20%
  - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 онд 660,000.00 мянга 2025 онд 792,000.00 мянга болгосон.

- ▶ Оюу Толгой уурхайн цогцолборт ОТОНАҮЭ-ийн Хорооноос зохион байгуулсан ажил хаялтын үед МҮЭ-ийн Холбооноос Хамтын гэрээ эхлүүлэх тухай заавар зөвлөгөө өгч ажиллав. 2024 оны 7 сарын 08





# МЭХГУУЭ-ИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

- ▶ МЭХГУУ-н ҮЭ-ийн гишүүдийн тоо өнөөдрийн байдлаар 101 салбарын хороодын нийт 22,708 гишүүнтэй болсон. Үүнээс Улаанбаатар хотын 9,804, хөдөө орон нутгийн 12,904 гишүүнтэй байна.
- ▶ Холбооноос мэргэжил эрх зүйн зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэн 2024 онд ҮЭ-ийн хороонүүд шинээр зохион байгуулагдлаа.
  - Энержи Ресурс ХХК-ийн ҮЭ-ийн хороо,
  - Рэдпаф Монгол ХХК-ийн ҮЭ-ийн хороо
  - Баян-Айраг ХХК-ийн ҮЭ-ийн хороо
  - Таван толгой түлш ХХК-ийн ҮЭ-ийн хороо





# МЭХГУУҮЭ-ИЙН ХОЛБООТОЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН УУЛЗАЛТУУД ХИЙГДЛЭЭ

- ▶ Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны дарга Д.Долгор, уул уурхайн салбар хариуцсан нарийн бичгийн дарга А.Дагвадорж нар Оюу толгой ХХК-ийн ҮЭ-ийн хорооны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Идэр болон тэргүүлэгчид, ажлын хэсгийн гишүүдийг хүлээн авч “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын хэрэгжилт, илүү цагийн хөлс болон бусад асуудлаар уулзалт хийв.





# МЭХГУУҮЭ-ИЙН ХОЛБООНООС ЗӨВЛӨМЖ АВЧ АЖИЛЛАВ

- ▶ ҮЭ-ийн Хорооны дарга ажил хүлээн авсан даруй МЭХГУУҮЭ-ийн Холбооны удирдлагуудтай ахны уулзалт хийж зорилго чиглэл хэлэлцэв.
- ▶ МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны гишүүн байгууллага болох Оюу толгой ХХК-ийн УУАҮЭ-ийн Хорооны гишүүд, сонгуультнууд, Оюу толгой ХХК-ийн удирдлагын багийнхантай МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч С.Эрдэнэбат, салбарын ҮЭ-ийн Холбооны дарга Д.Долгор нар 2024 оны 4 сарын 24-ний өдөр уурхайн талбайд уулзалт хийсэн
- ▶ Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын “Уурхай дахь ХҮН!” үндэсний зөвлөгөөнд ҮЭ-ийн Хорооноос оролцлоо.







## ОЮУ ТОЛГОЙН ОРОН НУТГИЙН АЖИЛЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

- ▶ Оюутолгойн Орон нутгийн ажилчдын ҮЭ-ийн Хорооны төлөөлөлтэй 2024.06.13 ны өдөр Улаанбаатар хотод анхны уулзалтаа амжилтай зохион байгууллаа. Уулзалтаар ажилчдын нийтлэг ашиг сонирхлыг дээдлэн Хамтын гэрээний саналуудыг нэгтгэн ажиллах Ажлын хэсгийг яаралтай зохион байгуулахаар шийдвэрлэлээ.







# НЭГДМЭЛ ЗОРИЛГО, ХАМТЫН АЖИЛЛАГАА ОЮУ ТОЛГОЙН ОРОН НУТГИЙН АЖИЛЧДЫН ҮЙЛДЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООТОЙ



- 2024 оны 8 сарын 23-ны өдрөөс 2024 оны 11 сарын 21 хүртэл нийт 51 удаагийн хурал уулзалт хийгдэж,
- Хамтын гэрээг 2024 оны 11 сарын 21 – ны өдөр Гурван тал баталгаажуулан, Уурхайн цогцолбор болон УБ хот, ДЗ, ХБ оффисын 3113 ажилтнуудад нийт 87 удаагийн уулзалтаар танилцуулга мэдээлэл хамтран хийгдсэн байна.
- Гишүүд ажилтнуудын эрх ашиг, цалин хөлс нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилго нэг ҮЭ-ийн Хороодууд хамтран ажиллаж ХАМТЫН ГЭРЭЭ-г үзэглэсэн түүхэн амжилтыг бүтээлээ.



# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ГАДААД ХАРИЛЦАА

IndustriALL Global Union

Lender audit-Европын Сэргээн босголт, Хөгжлийн банкны Зээлдүүлэгч нарын аудитад доорх асуудлуудыг уламжлав.

- МЭХГУУ-н ҮЭ-ийн холбооны урилгаар Олон улсын Аж үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбоо (IndustriALL Global Union)-ны Зүүн өмнөд Азийг хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга Рамон Кертеса-тай наймдугаар сарын 18-22-ны өдрүүдэд Монгол Улсад ирж ажиллах үед ҮЭ-ийн Хорооны үйл ажиллагааг танилцуулан тэдний хүсэлтээр биечлэн уулзалт хийсэн.
- Хамтын гэрээ хэлэлцээрийн үед IndustriALL Global Union-ны Азийг хариуцсан Дарга, Ерөнхий нарийн бичиг болон МЭХГУУ-н ҮЭ-ийн Холбооны дарга Д.Долгор нарийн бичиг Л.Дагвадорж нар оролцон, хамтран ажиллах, зөвлөмж авч санал солилцох уулзалтыг ҮЭ-ийн Хороо онлайнаар зохион байгуулж ажилласан.
- Lender audit-ийн хүсэлтээр Уурхайн цогцолборт 2024-09-17-ний өдөр уулзалт хийсэн.
- Цалин бодох аргачлалыг тодорхой болгох, аудит оруулах боломжтой эсэх, хүмүүсийн цалин хөлс эргэлзээ ихтэй байгаа тухай
- EPR-ийн үнэлгээг жилийн бонустой холбох нь шудрага бус байгаа, хүний эрх зөрчсөн асуудал гэж үзэж байгаа тухай
- Цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийт ажилтнуудын илүү цагийн нэмэгдэл олгохгүй байгаа тухай
- Хөдөлмөрийн тухай хуулийн зөрчигдөж байгаа заалтууд ,гэрээ хэлэлцээрээр шийдэлд хүрээгүй нөхцөлд дараагийн арга хэмжээг авч ажиллах тухай санал хүсэлтээ тус тус илэрхийлэв.



# ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮДИЙН СУРГАЛТ

- ▶ ҮЭ-ийн сонгуульт ажилтнуудыг манлайлалын болон гэрээ хэлэлцээр хийх тухай мөн хөдөлмөрийн харилцааны сургалтуудад хамруулан ажиллах нөхцөл боломжийг дэмжих зорилгоор холбогдох сургалтууд авч идвэхтэй оролцлоо. Үүнд:
- ❖ “Компанийн засаглалын сургалт” болон “Хэлцэл хийх тухай” сургалтуудыг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын Сургалт судалгааны хэлтэс, ҮЭ-ийн Хороо хамтран зохион байгууллаа. 2024 оны 8 сарын 21-ний өдөр.
- ❖ Ажил олгогчоос санаачлан зохион байгуулсан “Гэрээ хэлэлцээр хийх” тухай Дэйл Карнеги-ийн сургалтад 2024-08-23-ний өдөр оролцов.
- ❖ “Mnpartners” хуулийн фирмээс зохион байгуулдаг “Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа” сургалтад 2024-08-24-ний өдөр Хамтын гэрээний хэлэлцээрт оролцох Тэргүүлэгчид хамрагдлаа.
- ❖ Ажил олгогчоос санаачлан зохион байгуулсан Манлайллын сургалтад Хамтын гэрээний хэлэлцээрт оролцсон Тэргүүлэгчид 2024-11-23,24,25-нд оролцлоо.

**АНХААРАЛ ТАВЬСАН ТА БҮХЭНД  
БАЯРЛАЛАА**

